

ЯПОНЫ ЗАСГИЙН ГАЗРААС МОНГОЛД ОЛГОСОН ЗЭЭЛ

*Ж.Уянга**

1990 онд Монгол орон ардчилсан нийгмийн тогтолцоонд шилжиж, зах зээлийн эдийн засагт шилжсэн тэр үеэс шилжилтийн үеийн бэрхшээлийг даван туулахад санхүү, эдийн засгийн уналтыг зогсоох, ард түмний аж байдлыг тогтвортой түвшинд байлгах зорилгоор гадаад улс орнууд, олон улсын байгууллагуудын хөнгөлөлттэй зээлийг авч ашиглаж ирсэн билээ. Эдийн засгийн үндэс суурь нь бүрэн бэхжээгүй, зах зээлийн эдийн засгийн шилжилтийн үед байгаа Монгол улсад үзүүлэх Японы Засгийн газрын Хөгжлийн Тусламжийн хэмжээ жилээс жилд өсөж, тусламж үзүүлж буй салбарын цар хүрээ эрс өргөжиж Япон улс Монгол улсын хувьд хамгийн том хандивлагч орон болсон юм. Японы Засгийн газрын хөгжлийн тусламж нь өнөөдөр дэлхийн шинэ тулгар хөгжиж байгаа олон орныг хамарч тэдгээр орнуудын хөгжлийн явц дахь тулгамдсан хүнд хэцүү асуудлуудыг шийдэхэд ихээхэн хувь нэмэр оруулж байна. Иений хөнгөлөлттэй зээл нь хөгжиж буй орны том хэмжээний хөрөнгө оруулалтын хомсдолыг нөхөх үүрэгтэй. Түүний хажуугаар хөгжиж буй оронд эргүүлж төлөх үүрэг хүлээлгэдэг нь тухайн орны зүгээс эдийн засгийн бие даасан хөгжлийн төлөө зорилго тавьж, үр дүнд хүрэхээр өөрийн хүчин чармайлт гаргахыг шаарддаг.

Зах зээлийн эдийн засаг бүхий ардчилсан нийгэм рүү шилжих Монгол улсын хүчин чармайлтыг дэмжих зорилгоор Дэлхийн Банк, Японы Засгийн газрын санаачилгаар хандивлагч орнууд, олон улсын санхүү, эдийн засгийн байгууллагуудын чуулга уулзалтуудыг 1991 оноос хойш найман удаа зохион байгуулсан юм. Энэ хугацаанд хандивлагч орнууд ба олон улсын байгууллагууд манай улсад нийтдээ 2,6 тэрбум ам.долларын зээл, тусламж үзүүлэхээр тохиролцсоноос манай улс 1,9 тэрбум ам.доллар буюу нийт зээл, тусламжийн 71,9 хувийг нь авч ашиглаад байна. Үүнд Япон улсаас үзүүлсэн зээл, тусламжийн хэмжээ ихэнх хувийг эзэлж байна. Тухайлбал, 1991-2000 онд нийт хандивлагч орнууд 613, 3 сая ам.долларын буцалтгүй тусламж амласнаас гүйцэтгэл нь 535,9 сая ам.доллар болсны дотор Япон улсын 458,1 сая ам.долларын тусламж хэрэгжижээ.

2001 онд Парижид болсон хандивлагчдын зөвлөлгөөнд оролцсон улсууд, Олон улсын банк нийтдээ 330 сая ам.долларын

*Ж.Уянга - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан, магистр

тусламж амласны дотор Япон улс 118 сая ам.долларын тусламж, зээл амлаж хандивлагч орнуудаас тэргүүн байрыг зээлсээр байна¹.

Өнөөдөр манай улсын гадаадаас авч буй нийт зээл тусламжийн гуравны нэг илүү нь Японд ноогдож байгаа юм. Монгол улс Японоос зээл тусламж авч байгаа дэлхийн 100 гаруй улс орны дотор эхний аравт орж байна².

Манай улс эдийн засгийн бууралтыг зогсоох, бүтцийн өөрчлөлтийг хэрэгжүүлэх, харьцангуй бие даасан эдийн засгийн бүтцийг бий болгох суурь нөхцөлийг бүрдүүлэх үндсэн зорилгын үүднээс Японы Засгийн газраас хөнгөлөлттэй зээлийг авч ашиглаж ирэв.

Японы Засгийн газрын хөгжлийн тусламжийг дэлхийн 160 гаруй улс авч ашиглаж байгаагаас Монгол улс буцалтгүй тусламжаар 17-р, хөнгөлөлттэй зээлээр 36-р, нэг хүнд ноогдох хөгжлийн тусламжийн хэмжээгээр нэгдүгээр байранд явж байна³.

Япон улсын Засгийн газраас хөгжлийн албан ёсны тусламжийн хүрээнд 2000 он хүртэлх хугацаанд нийт 36,1 тэрбум иений хөнгөлөлттэй зээлийг олгосон байна⁴.

Он сар	Хөнгөлөлттэй зээл	Нийт хэмжээ /тэрбум иенээр/	Хугацаа	Хүү
91.10.29	Барааны зээл	4,836	30 жил	1,0%
93.02.05	Барааны зээл	2,459	25 жил	1,0%
93.11.25	Төмөр замын тээх нэвтрүүлэх хүчин чадлыг сайжруулах төсөл, төсөл, 1 дэх үе шат	3,321	30 жил	1,0%
95.01.25	Төмөр замын төсөл, 2 дахь үе шат	4,753	30 жил	2,6%
95.10.20	УБ-ын 4-р Цахилгаан станцын шинэчлэлт, 1 дэх үе шат	4,493	30 жил	2,3%
97.02.25	Багануур Шивээ-Овоогийн нүүрсний уурхайг хөгжүүлэх төсөл, 1 дэх үе шат	5,827	30 жил	2,3%
98.02.10	Нүүрсний уурхайг хөгжүүлэх төсөл, 2 дахь үе шат	4,298	30 жил	2,3%
2001	УБ-ын 4-р Цахилгаан станцын шинэчлэлт, 2 дахь үе шат	6,139	40 жил	0,75%
Нийт		36,126		

*Эх материал “Вага куни но кэй зай кио рёку” Токио 1999 он⁵

Ардчиллын эхний жилүүдэд эдийн засгийн гүнзгий хямрал нүүрлэж байсан үед 1991 онд Японы Засгийн газрын хөнгөлөлттэй зээлээр өргөн хэрэгцээний бараа, нефть, шатахуун худалдан авч зарим чухал төслийг санхүүжүүлэх эх үүсвэр болгон ашиглажээ. Мөн дээрх

зорилгоор 1993 онд хөнгөлөлттэй зээл авсан бөгөөд эдгээр зээл нь нэн тааламжтай нөхцөлөөр хийгдсэн юм. Хоёр засгийн газрын хооронд байгуулсан гэрээний дагуу зээлийг эргүүлэн төлж эхлэх хугацаа 2001 оноос эхлээд байна⁶.

“Монголын төмөр замын тээн нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх” төслийг Япон улсын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлэх тухай Засгийн газар хооронд албан ёсны Ноот бичгийг солилцсоны дагуу 1993 оны 11 дүгээр сард, 1995 оны 1 дугаар сарын 20-нд тус тус гэрээ байгуулан төслийг 2 үе шаттайгаар хэрэгжүүлэх болсон юм.

Төслийн хүрээнд замын төмөр худалдан авах, төмөр замын холбооны тоног төхөөрөмж нийлүүлэх, хөдлөх бүрэлдэхүүн худалдан авах /суудлын вагон 30ш, ачааны вагон 455 ш, зүтгүүр 2 ш/, депогийн засварын тоног төхөөрөмж авч суурилуулах ажил тус тус хийгджээ⁷.

IV Цахилгаан станц нь манай улсын нийт цахилгаан эрчим хүчний 70 орчим хувь, Улаанбаатар хотын дулааны эрчим хүчний 70 орчим хувийг үйлдвэрлэдэг хамгийн том цахилгаан станц бөгөөд 90-ээд оны эхний жилүүдэд үе үйл ажиллагааны доголдолд орж эхэлсэн юм. Монгол улсын Засгийн газрын хүсэлт ёсоор Японы Засгийн газар 1991 оноос нэн шаардлагатай багаж хэрэгслийг нийлүүлж эхэлсэн бөгөөд станцийг шинэчлэн засварлах ажилд 1995 онд Японы Засгийн газар 4,493 тэрбум иенийн хөнгөлөлттэй зээл олгосон юм. Үүний үр дүнд Цахилгаан станцын доголдлыг арилгаж тогтвортой ажиллагааг хангахын тулд удирдлагын системийг сайжруулах, зарим хаалт, халах гадаргууг хэсэгчилэн солих ажлыг хийв. Түүнчлэн цахилгаан станцын үнс бууруулах шугамын бөглөрөлт болон тоосон системийн элэгдэлтийн эсрэг, тоос хэмжилт, дулааны тоноглол, угааны цахилгаан фильтр, цооролтыг бууруулах ажиллагааг сэргээх, засварын багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийн эдэлгээг уртасгах зэрэг чиглэлүүдээр өргөн хүрээтэй шинэчлэлт явуулав. Бусад машин тоноглолыг үргэлжлүүлэн шинэчлэн засварлах шаардлагатай ажээ. Дээрхи ажилд шаардагдах 6,139 тэрбум иенийн үнийн дүн бүхий онцгой хөнгөлөлттэй зээлийг Японы Засгийн газраас олгох хэлэлцээрийг 2001 оны 2 дугаар сард Токио хотноо байгуулав. Шинэчлэлийн үр дүнд станцын үйл ажиллагаа олон тал дээр сайжирч, яндангаас гарах утаан дахь тортогийн хэмжээ болон станцад гарах гэмтэл аваарын тоо багасч, хотын цахилгаан тасалдалт бууран, ОХУ-аас импортоор авах цахилгаан эрчим хүчний хэмжээг ч багасгаж чадах болжээ.

Багануур, Шивээ-Овоогийн нүүрсний уурхайг Японы хөнгөлөлттэй зээлээр шинэчлэн тоноглох төслийг хэрэгжүүлэх хүсэлтийг

1995 онд тавьсан. Төслийн нэгдүгээр шатыг хэрэгжүүлэхэд зориулж Японы Засгийн газраас 5 тэрбум 827 сая иений хөнгөлөлттэй зээл олгох тухай албан ёсны Ноот бичгийг 1997 оны 2 дугаар сарын 25-нд солилцсон. Энэ шатанд уурхайн гүний усны шүүрүүлэх систем, нүүрс хамах, ялгах байгууламжуудыг байгуулах зэрэг ажлыг гүйцэтгэсэн.

Японы засгийн газраас олгож ирсэн зээл нь хүү багатай, эхний 10 жилд хүүгүй гэх мэт нөхцөлтэй байсан нь манай орны хувьд маш чухал ач холбогдолтой юм. Төслийн хоёрдугаар шатанд зориулж 4 тэрбум 298 сая иений хөнгөлөлттэй зээл олгох тухай албан ёсны Ноот бичгийг 1998 оны 2 дугаар сарын 10-нд солилцсон. Энэ шатанд хөрс хуулалтын ажил, уурхайн холбооны тоноглолыг сайжруулах болон тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний газрыг шинээр барих зэрэг ажил хийгджээ.

1990 оноос хойш авч ашигласан хөнгөлөлттэй зээлийн байдлаас үзвэл манай улс эхний үе буюу 1990-1993 онд бараа таваарын хомсдол, эрчим хүчний дутагдлыг арилгах, өвлийг давах, нефтийн бүтээгдэхүүн худалдан авах, хүнсний хангамжийг нэмэгдүүлэх зэрэг цаг үеийн бэрхшээлийг шийдэхэд зориулж, гадаад худалдааны балансыг нөхөхөд ашиглажээ. Хоёрдахь үе буюу 1994-1995 онд дунд хугацааны төслийг хэрэгжүүлэх, үйлдвэрийн тоног төхөөрөмжийг шинэчлэх, жижиг дунд үйлдвэрийг сэргээх, хөгжлийн судалгаа хийх зэрэгт чиглүүлэн ашиглаж, гуравдахь үе болох 1996 оноос хойш урт хугацааны төслийг санхүүжүүлэх, авто болон төмөр зам, уул уурхай, эрчим хүч зэрэг дэд бүтцийн салбар, улс орны ирээдүйн хөгжлийн бааз суурийг бий болгох хэлбэр рүү хандуулан ашиглаж иржээ.

Тусламжийн тоо хэмжээг жилээс жилд өсгөж ирэхдээ хөнгөлөлттэй зээлийн хэмжээг нэг түвшинд барих, эргэж төлөгдөх нөхцөлийг судалж үзсэний үндсэн дээр зээлийг олгох зэрэг чиг бодлогыг барьж ирсэн бөгөөд энэ нь чухамдаа Монгол улсыг ирээдүйд өрийн дарамтанд унагахгүй байх зорилго агуулсан сайн санааны илрэл, чухал алхам юм.

2002 онд УИХ-ын дарга С.Төмөр-Очир тэргүүтэй Монголын парламентын төлөөлөгчид Япон улсын засгийн газрын урилгаар албан ёсны айлчлал хийсэн билээ. Энэхүү айлчлалын гол зорилго нь эдийн засгийн хамтын ажиллаганд чиглэсэн юм. Япон улсын эдийн засгийн асуудал хүндрэлтэй байгаагаас шалтгаалан бусад улс оронд үзүүлэх зээл тусламжаа бууруулах бодлого баримталж байгаа бөгөөд манай талаас Монгол улсад үзүүлэх зээл тусламжаа бууруулахгүй байх хүсэлт

тависан юм. Монгол улс тус улсаас сүүлийн арван жилд зээлсэн зээлийн хүүгээ цаг тухайд нь төлж байгаа бөгөөд 2003 оноос үндсэн зээлээ төлнө гэж мэдэгдсэн байна⁸.

Япон улсын зээл тусламж, эдийн засгийн хамтын ажиллагаа нь манай улсын аливаа төвөгтэй асуудлыг шийдвэрлэх, нийгмийн амьдралд бодитой хувь нэмэр болох чиглэлийг голлож ирснээрээ онцлог ач холбогдолтой юм.

Хоёр улсын Засгийн газрын эдийн засгийн өндөр түвшингийн төлөөлөгчдийн уулзалт хуралдаан болж зээл, тусламжийн хэрэгжилт, үр дүнгийн талаар хэлэлцэн дүгнэлт гаргахад зарим төслийн үр дүн, хэрэгжилт муу, ашиглалтын аргачлал дутагдалтай байсныг тэмдэглэх нь зүйтэй болов уу. Энэ нь манай талаас зээл, тусламж авах урьдчилсан судалгаа хангалтгүй хийгдсэн, хүсэлт гаргах шатнаас эхлээд төслийг хэрэгжүүлж дуусах хүртэлх үүрэг хариуцлага сул байсантай холбоотой юм. Жишээлбэл: Японы тусламж зээлээр 1993 оны сүүлээр Дархан хотод жилдээ 100 мянган тонн ган цувимал үйлдвэрлэх хүчин чадалтай хар төмөрлөгийн үйлдвэрийг 57,8 сая ам.долларын зээлийн хөрөнгөөр барьж байгуулсан. Уг зээлийн баталгааг Японы Засгийн газраас гаргаж өгчээ. Энэ үйлдвэр манай улс зах зээлийн эдийн засагт шилжих шилжилтийн эхэн үед гадаад улсын зээлийн хөрөнгөөр баригдсан, манайд урьд өмнө нь байгаагүй томоохон үйлдвэр болсон юм. 1995 оны эхээр 2000 тонн хар төмрийн бэлдэцийг Япон улсад гаргасан нь энэ үйлдвэрийн бүтээгдэхүүний анхны экспорт байсан юм. Одоо тус үйлдвэр бүтээгдэхүүнээ ОХУ, БНХАУ, Японд экспортолж байна. Гэвч үйлдвэр ашиглалтад орсон тухайн үе нь манай орны эдийн засаг уналтад орсон үе байсан учир эхнээсээ төрийн дэмжлэг зохицуулалт дутагдаж, эргэлтийн хөрөнгөгүй болж, гадаад дотоодын зах зээлийн эрэлт хэрэгцээ хэдийгээр их байсан боловч хүчин чадалдаа хүрч ажиллаж чадахгүйгээр өнөөг хүрч ирсэн нь нэн харамсалтай юм⁹.

Урьд нь зээл, тусламжийн асуудлыг Үндэсний хөгжлийн газар, Монголбанк, яамуудаар дамжуулж хариуцуулж өгсөн боловч яамдын эрх үүргийг зааглаж өгөөгүйгээс чиг үүрэг давхардах, тогтсон систем, үйл ажиллагааны нягт уялдаа холбоо байгаагүйгээс төдийлөн үр дүнгээ өгөөгүй. Ямартаа ч гаднаас авсан зээл, тусламжид хяналт тавих, зохицуулах цаг болсон гэж үзэж байна. Эргэн төлөх нөхцлөө бодсон, шингээх чадвараа зөв тооцсон, бодит судалгаатай байж л зээлийг үр өгөөжтэй ашиглана. Түүнчлэн, өнөөгийн шилжилтийн үед гадаад тусламжид түшиглэх хувь хэмжээ өндөр байгаа өрөөсгөл талыг засан

сайжруулж, цаашдаа гадаадын тусламжид түшиглэсэн байдлаас ангижирч, эдийн засгийн бие даасан байдлыг бий болгоход чухал болов уу.

Ер нь зах зээлийн эдийн засагт тууштай шилжиж чадахгүй, хуучинтайгаа зууралдаж, хүний эрхийг хүндэтгэх явдлыг баталгаажуулж чадахгүй орнууд хөгжлийн тусламжинд найдах хэрэггүй биз. Хэрэв ямар нэгэн хөгжиж буй орон хүний хувийн санаачлагыг дарангуйлж байх юм бол жишээ нь мэдээлэл чөлөөтэй олж авах эрхийг хязгаарлаж байхад гаднаас үзүүлэх тусламж үр нөлөө үзүүлж чадахгүй гэж хөгжингүй орнууд үзэж шалгуур тавьдаг байна.

Манай Засгийн газраас Гадаадын зээл, тусламжийг хуулиар зохицуулах тухай хуулийн төслийг УИХ-д өргөн бариад байна. Зээлд тавих нөхцөл шаардлагыг зөв гаргаж, үр ашигт гол анхаарлаа хандуулах, төсөвт дарамт болохооргүй тооцоо, судалгаан дээр үндэслэсэн байхаас гадна УИХ-н төсвийн хүрээний мэдэгдлийг хэлэлцэн шийдвэрлэхдээ авч болох зээлийн түвшинг тогтоож өгдөг байх зэрэг зайлшгүй зохицуулах ёстой зүйлүүдийг төсөлд тусгасан байна¹⁰.

Түүнчлэн зээл тусламжийн үр өгөөжийг дээшлүүлж, зарцуулалтыг оновчтой болгож чадсанаар Монгол улсын эдийн засгийн хурдацтай хөгжлийг хангах, ард иргэдийнхээ аж амьдрал, эрүүл мэнд, боловсролын түвшинг дээшлүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

Ишлэл, зүүлт

1. “Гадаад харилцаа” Монгол улсын гадаад хэргийн яамны мэдээллийн товхимол №6/101/ 2001 он
2. “Монгол-Японы харилцаа:эрт, эдүгээ” УБ.2001 он
3. Б.Сэржав “Монгол-Японы харилцаа:XX зууны сүүлийн хагаст”УБ.2003 он
4. Мөн тэнд
5. ”Вага куни но кэй зай кио рёку” Токио 1999 он
6. Б.Сэржав “Монгол-Японы харилцаа:XX зууны сүүлийн хагаст”УБ.2003 он
7. “Монгол-Японы харилцаа:эрт, эдүгээ” УБ.2001 он
8. “Засгийн газрын мэдээ” 2002.03.07 №9/945/
9. Т.Намжим “Япон орон тоймлон харвал”,УБ.1999 он
10. ”Өнөөдөр” 2003.05.31, №129 /1867/